

ДУГУЙН СУРГАЛТЫН АЖЛЫН ДААЛГАВАР

| № | АГУУЛГА | |
|---|---------------------|--|
| 1 | Зорилго | Ажилтнуудыг дугуйн чиглэлээр мэргэшүүлж, ур чадварыг нэмэгдүүлнэ. |
| 2 | Зорилт | Сургалтын хэрэгцээнд үндэслэн хамрагдах хүрээг хангаж чадахуйц чанартай, үр дүнтэй сургалтыг авах. |
| 3 | Хэрэгцээ, шаардлага | Дугуйнд үзлэг хийж, гэмтлийг тодорхойлох, засварлах, задалж угсрах, дугуй задлах үеийн аюулгүй ажиллагааг хангах зэрэг чадваруудыг эзэмшсэнээр дугуйны үүдэлтэй үйлдвэрлэлийн сул зогсолтыг гаргахгүй байх, аюулгүй ажиллагааг хангах. |
| 4 | Сэдэв | <p>Сургалтыг дараах сэдвүүд болон шаардлагатай бусад сэдвүүдийг нэмж явуулах;</p> <ol style="list-style-type: none"> 1. ХАБЭА-н тухай хууль, дүрэм, журам, стандарт; 2. ХАБЭА-н менежмент, системийн тухай; 3. Сургагч багшийг мэргэшүүлэх, арга зүйн талаарх ойлголт; 4. Хүнд даацын машин, механизмын дугуй: <ul style="list-style-type: none"> • Дугуй ашиглалтын тухай • Дугуйн мэдээлэл, хадгалалт • Дугуйн гэмтэл • Цаг агаарын нөлөөлөл, дугуйн дотоод температур, хүчин зүйлс • Дугуйн бүтэц, задаргаа • Тэнхлэг тохиргоо • Машин удирдах чадвар, жолоодлого дугуйнд нолоолох нолоол • Дугуйн тасралтгүй ажиллах байдал • Ачаа, даац тохируулах • Дугуйн элэгдэл, норм • Дугуйн зориулалт, ангилал |
| 5 | Хэлбэр | Онол болон практик хосолсон байдлаар |
| 6 | Тавигдах шаардлага | <p><u>Сургалтын байгууллагад:</u></p> <ul style="list-style-type: none"> • Эрх бүхий байгууллагаас тухайн чиглэлээр үйл ажиллагаа явуулах зөвшөөрөлтэй байх; • Тухайн чиглэлээр 3-аас доошгүй жил үйл ажиллагаа явуулж байсан туршлагатай; • Сүүлийн 2 ба түүнээс дээш жил уул уурхайн салбарт тухайн чиглэлээр сургалт явуулж байсан туршлагатай; • Тухайн чиглэлийн мэргэшсэн, мэргэжлийн туршлагатай багш нартай байх; • Цахим сургалтыг явуулж байсан туршлагатай байх; • Сургалтын хэрэглэгдэхүүн, гарын авлагаар хангах; • Сургалтын зориулалтын анги танхим, дадлага хийх тоног төхөөрөмжтэй байх; • Сургалтад хамрагдсан ажилтнуудад мэргэжлийн үнэмлэх, сертификат олгох; |

| | | |
|----|--------------|---|
| | | <p><u>Сургагч багшид:</u></p> <ul style="list-style-type: none"> • Сургагч багш нь тухайн чиглэлээр мэргэшсэн байх; • Сургагч багш нь тухайн чиглэлээр 3 ба түүнээс дээш жил ажилласан ажлын туршлагатай; • Сургалтын хөтөлбөртэй, түүний дагуу сургалт явуулах; • Илтгэх ур чадвар, багшлах ёс зүй хэм хэмжээг мөрддөг байх; • Холбогдох хууль тогтоомжийн шинэчлэлт, эрх зүйн зохицуулалтын хүрээнд явуулах. |
| 7 | Хамрах хүрээ | “Салбарын Техник ашиглалт, засвар механикийн хэлтсийн ажилтнууд |
| 8 | Хугацаа | 2021 оны III, IV улиралд зохион байгуулах |
| | | “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн уурхайн ээлжийн хуваариас шалтгаалан сургалтыг давтамжтай явуулах. |
| 9 | Төсөв | Сургалтын танхим, сургагч багшийн цалин, сургалтын хэрэглэгдэхүүн, мэргэжлийн үнэмлэх /сертификат/ болон бүсэд зардал |
| 10 | Үр дүн | Мэргэжлийн ур чадвартай болж ажлын бүтээмж нэмэгдэнэ. |